



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

### Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй хавсралтад дурдсан нэр бүхий 17 банк бус санхүүгийн байгууллагуудын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнд хүргэж ажиллахыг хавсралтад дурдсан нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын 2-т заасан үүргийг хэрэгжүүлж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулаагүй тохиолдолд олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад дурдсан нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдэд анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн  
69.. тоот тогтоолын хавсралт



д/д	ББСБ-уудын нэр	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
1	“Майкро кредит инвестмент ББСБ” ХХК	Зээл	401,000,000
2	“Эйс ассошиэйтс ББСБ” ХХК	Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	401,000,000
3	“Арвин бураат ББСБ” ХХК	Зээл	600,000,000
4	“Гео финанс ББСБ” ХХК	Зээл	400,000,000
5	“Сакура финанс ББСБ” ХХК	Зээл	400,000,000
6	“Танил групп ББСБ” ХХК	Зээл	520,000,000
7	“И зэт финанс ББСБ” ХХК	Зээл	445,000,000
8	“Титус монголиа ББСБ” ХХК	Зээл	400,000,000
9	“Мөнгөн бүрэн ББСБ” ХХК	Зээл	400,000,000
10	“ББС велт ББСБ” ХХК	Зээл, гадаад валютын арилжаа	400,000,000
11	“Смарт менежмент ББСБ” ХХК	Зээл	401,000,000
12	“Фундаментал ББСБ” ХХК	Зээл, гадаад валютын арилжаа	400,000,000
13	“Сүлдэт тамган ББСБ” ХХК	Зээл	400,000,000
14	“Ачит капитал ББСБ” ХХК	Зээл	400,000,000
15	“Хос холбоо уул ББСБ” ХХК	Зээл	400,000,000
16	“Фин инвест ББСБ” ХХК	Зээл	530,000,000
17	“Монголын санхүүгийн хөгжлийн корпораци ББСБ” ХХК	Зээл	600,000,000